



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар Б/81

Ховд


**Баатарсүрэнгийн Түмэндэмбэрэлд
цалингүй чөлөө олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Баатарсүрэнгийн Түмэндэмбэрэл нь эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагаар 3 сарын цалингүй чөлөө хүссэн тул 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай цалингүй чөлөө олгосугай.

2. Б.Түмэндэмбэрэлийг чөлөөтэй байх хугацаанд ажил үүргийн хуваарилалт хийж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ӨНХБОЛД